

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.12.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа Сэлэнгэ аймгийн харьяат иргэдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон медалиар шагнах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Японы хөдөө аж ахуй, ойн Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн захирлын туслах Акио Нишияма, Монголын хөдөөгийн амьжиргааг сайжруулах, зөгийн аж ахуйг хөгжүүлэх төслийн дэд менежер Майко Мори нарыг хүлээн авч уулзлаа. Төслийн багийн зүгээс Ногоон аялал жуулчлал, зөгийн аж ахуйг хөгжүүлэх зорилтот аймаг нь Сэлэнгэ аймаг тул төсөл хэрэгжүүлж хамтарч ажиллах боломж байгааг илэрхийлсэн бол аймгийн Засаг даргын зүгээс мод тарих, төгөл байгуулах, нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулахад хамтарч ажиллах саналтай байгаагаа илэрхийллээ.

Сэлэнгэ аймаг АШУҮИС-тай хамтран ажиллах хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай эмч мэргэжилтнүүдийг бэлтгэх, одоогийн байгаа боловсон хүчнээ мэргэшүүлэн сургах ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж, уг ажлын хүрээнд эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг ажлын байрнаасаа хөгжиж, сурах боломжийг бүрдүүлэх үүднээс эхний ээлжид аймгийн Нэгдсэн эмнэлгийн 5 их эмч, 1 эмнэлгийн дунд мэргэжилтний сургалтын төлбөрийг хариуцан магистрт сургахаар боллоо.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Соёлын бүтээлч сар” нэг өнгө төрх, нэгдмэл агуулгын хүрээнд үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, түүх соёлоо сурталчлан таниулах, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалаар дамжуулан орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах эрхэм зорилгын дор нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

“Бичил уурхайн эрх зүйн зохицуулалт” сэдэвт сургалтыг Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журмын 9.1.4 болон 11.1.2-д заасан бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлон, оролцогчдод шинэ мэдээлэл олгох зорилгоор Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны хамтарсан хөтөлбөрийн дагуу бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл, хоршооны гишүүдийг хамруулан зохион байгууллаа.

Төрийн албаны тусгай шалгалтыг 2022 оны 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, удирдах албан тушаалын 12 сул орон тоо зарлагдсанаас 9 албан тушаалд 11 оролцогч өрсөлдөж, 9 албан хаагчийг нэр дэвшүүлсэн. гүйцэтгэх

албан тушаал /дэс түшмэл/-ийн 128 сул орон тоо зарлагдсанаас 28 албан тушаалд 31 оролцогч шалгалт өгч, тухайн албан тушаад нэр дэвшүүлэхээр шийдвэрлээд байна.

Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 1, 4, 8 дугаар заалтыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн тогтоолоор 61 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөлөө.

Монгол Улс эрх чөлөө, тусгаар тогтнолоо зарлан тунхаглаж, анхдугаар үндсэн хуулиа баталсны 98 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”, Монголын тусгаар тогтнол”-ын түүхэн өдрүүдийг угтан “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг зохион байгуулж, 16 нас хүрч иргэний үнэмлэхээ гардан авч буй хүүхдүүд андгай тангаргаа өргөлөө. Мөн ёслолын арга хэмжээнд оролцсон сурагчдад иргэний улсын бүртгэлийн хууль, дүрэм, цахим гарын үсгийн талаар мэдээлэл өгч, тоон гарын үсэг олголоо.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Хөдөлмөрийн үр шимийн баяр” арга хэмжээг зохион байгуулах тухай А/499 дүгээр захирамжийн хүрээнд “ХӨДӨЛМӨРИЙН ҮР ШИМИЙН БАЯР-2022”, Сэлэнгэ аймгийн ургацын баярын арга хэмжээг зохион байгуулж, шилдгүүдээ тодорхойлж, шагнаж урамшууллаа. Үүнд:

- “Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлээр тэргүүлэгч сум”-аар Ерөө сум

- “Нэгж га талбайгаас хамгийн их улаан буудай хураан авсан аж ахуйн нэгж”-ээр Ерөө сумын “Ачит Оргил” ХХК

- “Газар тариалангийн салбарт шинэ техник, технологид хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж”-ээр Цагааннуур сумын “Сэлэнгэ Тариа” ХХК

- “Нэгж га талбайгаас хамгийн их төмсний ургац хураасан аж ахуйн нэгж”-ээр Мандал сумын “Эрдэнэ Энх Трейд” ХХК

- “Нэгж га талбайгаас хамгийн их хүнсний ногооны ургац хураасан ногоочин”-оор Мандал сумын ногоочин А.Гантулга

-“Хамгийн их жимс жимсгэнэ тариалсан аж ахуйн нэгж”-ээр Зүүнбүрэн сумын “Хаан жимс” ХХК

-“Эрт ургацын ногоогоор хамгийн их борлуулалт хийсэн ногоочин”-оор Орхон сумын “Их өнгөт Трейд” ХХК

-“Газар тариалангийн салбарын шилдэг механикжуулагч”-аар Цагааннуур сумын “Ургацын Хишиг” ХХК-ий механикжуулагч Б.Баттулга

-“Шилдэг хүлэмжийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж”-ээр Баянгол сумын “Бялхам Ивээл” ХХК

-“Жимсний суулгац тариалалт нэмэгдүүлж хамгийн их борлуулалт хийсэн иргэн, аж ахуйн нэгж”-ээр Баянгол сумын “Гурван Сээр” ХХК тус тус шалгарлаа.

Уг арга хэмжээний хүрээнд Орхонтуул сумын уугуул Монгол Улсын Хөдөлмөрийн баатар П.Цэрэндагвад хүндэтгэл үзүүлж, мөн Үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж Улс, аймаг, сумын цолтой 32 бөх барилдсанаас Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат Улсын начин Наранцогтын Баярбаатар түрүүлж, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын харьяат Улсын заан Цэдэнбазарын Одбаяр үзүүрлэн, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын харьяат Аймгийн Хурц арслан

Даваадоржийн Төрболд, Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат аймгийн Арслан Эльбусын Бат-эрдэнэ нар шөвгөрлөө.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 хяналтын чиглэлээр тандалт судалгааг 3 асуудлаар Мэргэжлийн сургалтын төв, насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд 3 объектод, Соёлын төв, ордны номын сангийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд 43 объектод, Өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд 1 объектод, төлөвлөгөөт бус хэлбэрээр, хүнсний худалдааны газруудад худалдаалагдан буй “Киндер” нэрийн бүтээгдэхүүнд тандалт судалгаа хийх тухай удирдамжаар 55 объектод нийт 4 асуудлаар 102 объектод хийж гүйцэтгэж, тандалт судалгааны явцад 301 заалттай 23 зөвлөмжийг өгч биелэлтийг тооцоход 85.5 хувьтай байна.

Мөн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 хяналтын чиглэлээр 10 асуудлын хүрээнд хяналт шинжилгээг хийхээс 8 асуудлын хүрээнд 419 шинжилгээт хяналт шалгалтыг хийсэн. Үүнд: шалгалтад хамрагдаагүй ундны усны эх үүсвэр, УТБ-ны усны чанар, аюулгүй байдалд 38, төвлөрсөн бус усан хангамжтай эмнэлгүүдийн усны чанар, аюулгүй байдалд 10, төвлөрсөн бус ус хангамжтай сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын ундны усны чанар, аюулгүй байдалд 93, шалгалтад хамрагдаагүй ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд 4, хот суурин газрын хөрсний бохирдлын байдалд 43, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн хоол”-ны илчлэг, шимт бодисыг тодорхойлох зорилгоор 79, таримлын үрийн чанар, үрийн нөөцийн бүрдүүлэлт, хүнсний улаан буудайн чанарт 43, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл тодорхойлохоор 109 нийт 419 дээж авч Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулан шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 228 дүгнэлтийг үйлдэж аж ахуйн нэгж байгууллага, иргэнд хүргүүлэв. Өмнө оны шинжилгээт хяналт шалгалтын эерэг сорьцын тоотой харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эхлэхээс өмнө аюул, эрсдэлийг хянах зорилгоор хянан баталгаажуулах үйл ажиллагааг 3 хяналтын чиглэлээр 6 асуудлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах үед 4, Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан хяналт хийж 3, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж 76, Нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан хяналт хийж 3, мал эмнэлгийн үйлчилгээний болон малын эм хангамжийн байгууллагад урьдчилсан хяналт хийж, баталгаажуулах үйл ажиллагаанд 1, Согтууруулах ундаа үйлдвэрлэлийн төсөл сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл сунгах ажлын хэсэгт ажиллан 2 нийт 89 дүгнэлтийг үйлдэж хүргүүлсэн байна.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 5 асуудлын хүрээнд 560 объектын үйл ажиллагаанд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ.

Хяналт шалгалтын явцад 931 зөрчлийг илрүүлж 678 буюу 72.8 хувийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулахаар 234 заалттай 28 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлт 77 хувьтай, зөрчил гаргасан 2 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 5.300.000 (таван сая гурван зуун мянга) төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 300.000 барагдуулж, 5.000.000 төгрөгийн хугацаа болоогүй байна.

Эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж байсан 2 газрын үйл ажиллагааг зөрчлийн арилгах хүртэл түр хугацаагаар зогсоох арга хэмжээг авч ажилласан.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Үйлчилгээний баталгаажуулалтаар Сүхбаатар, Түшиг, Цагааннуур, Шаамар, Мандал, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын 13 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний газрыг тохирлын үнэлгээнд хамруулж 15 үйлчилгээний газар 5 хүнсний дэлгүүр, 1 хүнсний мухлаг, 1 махны мухлаг, 1 худалдааны агуулах, 2 зоогийн газар, 1 кафе, 2 караоке үйлчилгээ, 2 зочид буудлын үйлчилгээнд Монгол Улсын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588 : 2008”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Караокед тавих ерөнхий шаардлага MNS 6909:2021”, стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон.

Экспорт баталгаажуулалтаар Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй “Болд төмөр Ерөө гол” ХХК-ий экспортод гаргаж буй төмрийн хүдэрт “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал - MNS 6249 : 2011” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, 33 ширхэг экспортын тохирлын гэрчилгээ олголоо.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 4 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 4 нэрийн 5 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Сүхбаатар сумын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд Хэмжилзүйн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс ашиглагдаж буй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах ажлыг хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: 9 сумын 30 шатахуун түгээх газрын 96 шатахуун түгээгүүрийг шалган баталгаажуулсан.

Шалган тохируулгаар: 2 байгууллагын лабораторийн 6 электрон жин, 8 туухай, 2 шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Зүүнбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 4 цусны даралтын аппаратад баталгаажуулалтыг хийлээ.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тус сард 940 баримтаар 8,2 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

| д/д | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|--|---------------------|---------------------|-------------|
| 1. Орон нутгийн төсвийн нийт орлого | | 70,451,433.2 | 67,243,161.9 | 95.4 |
| 1.1 | Орон нутгийн төсвийн орлого | 40,786,267.9 | 40,044,340.4 | 98.2 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 17,231,883.0 | 11,293,731.4 | 65.5 |
| | Сумдын төсвийн орлого | 23,554,384.9 | 28,750,609.0 | 122.1 |
| 1.2 | Сумдаас авах орлогын шилжүүлэг | 3,780,829.2 | 2,592,344.8 | 68.6 |
| 1.3 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг | 10,162,694.9 | 10,824,738.4 | 98.8 |
| 1.4 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/ | 9,658,352.6 | 9,658,352.6 | 100.0 |
| 1.5 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/ | 3,546,867.1 | 3,546,867.1 | 100.0 |
| 1.6 | Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/ | 20,000.0 | 20,000.0 | 100.0 |
| 1.7 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 264,823.7 | 851,497.4 | 321.5 |
| 1.8 | Сум хөгжүүлэх сангийн орлого | 2,231,597.8 | 489,009.8 | 21.9 |
| 2. Орон нутгийн төсвийн нийт зарлага | | 70,451,433.2 | 49,578,775.8 | 70.4 |
| Орон нутгийн төсвийн нийт зарлага | | 70,451,433.2 | 49,578,775.8 | 70.4 |
| Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага | | 37,805,517.0 | 27,896,791.8 | 73.8 |
| Сумдын орон нутгийн хөгжлийн сан | | 9,119,862.2 | 6,042,050.3 | 66.3 |
| Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага | | 23,526,054.0 | 15,639,933.7 | 66.5 |
| 2.1 | Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт | 5,026,500.0 | 3,502,406.6 | 69.7 |
| | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан | 6,027,531.9 | 4,193,667.8 | 69.6 |
| | Халамжийн сан | 147,620.0 | 98,375.8 | 66.6 |
| | Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага | 8,569,558.6 | 7,018,183.4 | 81.9 |
| | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | 1,250,000.0 | 827,300.1 | 66.2 |
| Улсын төсөвт төвлөрүүлэх орлого | | 2,504,843.5 | | |
| 3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг | | 16,259,673.5 | 15,567,466.0 | 95.7 |
| 3.1 | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 6,096,978.6 | 5,526,716.2 | 90.6 |
| 3.2 | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 5,816,412.4 | 5,847,046.5 | 100.5 |
| | Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд | 117,785.0 | 117,785.0 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний | | | |

| | | | | |
|------------------------------------|--|--------------------|------------------|-------------|
| | зардалд | | | |
| | Хөрөнгө оруулалтын зардалд | 5,698,627.4 | 5,729,261.5 | 100,5 |
| 3.3 | Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 4,346,282.5 | 4,193,703.3 | 96,4 |
| | Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд | 3,927,531.9 | 3,774,952.7 | 96,1 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд | 397,100.0 | 397,100.0 | 100,0 |
| | Усан хангамжийн татаас | 21,650.6 | 21,650.6 | 100,0 |
| 4. Тусгай сангуудын зарлага | | 2,231,597.8 | 489,009.8 | 21,9 |
| 4.1 | Сумдын сум хөгжүүлэх сан | 2,231,597.8 | 489,009.8 | 21,9 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | | 2021 - X | 2022 – X | <u>2022-X</u> <u>2021-X</u> |
|-------------------------------------|--|----------|----------|--------------------------------|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | | |
| 1 | Талх, гурил, будаа | 1 400 | 1 700 | 121.4 |
| | Гурил /Алтантариа, I зэрэг, кг/ | 1 400 | 1 700 | 121.4 |
| | Талх /орон нутгийн, ш/ | 4 000 | 5 000 | 125.0 |
| | Нарийн боов /кг/ | 2 700 | 3 600 | 133.3 |
| | Будаа /кг/ | 2 500 | 3 300 | 132.0 |
| | Элсэн чихэр /кг/ | | | |
| 2 | МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | | | |
| | Хонины мах /кг/ | 8 500 | 8 500 | 100.0 |
| | Үхрийн мах /кг/ | 9 500 | 10 500 | 110.5 |
| | Адууны мах /кг/ | 7 500 | 8 000 | 106.7 |
| | Ямааны мах /кг/ | 7 500 | 7 500 | 100.0 |
| | Дотор мах, цувдай /цусгүй/ | 5 000 | 8 000 | 160.0 |
| | Хиам /чанасан, кг/ | 12 500 | 17 100 | 136.8 |
| 3 | СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | | | |
| | Сүү /задгай, л/ | 1 400 | 1 900 | 135.7 |
| | Сүү / савласан, л/ | 3 350 | 4 800 | 143.3 |
| | Тараг /задгай, л/ | 1 500 | 2 800 | 186.7 |
| | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 18 000 | 25 000 | 138.9 |
| | Айраг /л/ | 5 000 | | 0.0 |
| | Хуурай сүү /кг, Орос, 25 хувь тослогтой/ | 5 500 | 6 600 | 120.0 |
| | Өндөг /ш/ | 450 | 450 | 100.0 |
| 4 | Бүх төрлийн өөх тос | | | |
| | Ургамлын тос /л/ | 5 300 | 11 000 | 207.5 |
| | Өөхөн тос /кг/ | 3 000 | 3 000 | 100.0 |
| | Шар тос /кг/ | 23 000 | 25 000 | 108.7 |
| | Масло /задгай, кг/ | 5 000 | 7 500 | 150.0 |
| 5 | ХҮНСНИЙ НОГОО | | | |
| | Төмс /кг/ | 800 | 1 500 | 187.5 |

| | | | | |
|--------------------|--------------------------------------|-------|-------|-------|
| | Лууван /кг/ | 1 500 | 2 500 | 166.7 |
| | Манжин /кг/ | 2 000 | 2 500 | 125.0 |
| | Байцаа /кг/ | 1 300 | 2 500 | 192.3 |
| | Сонгино /кг/ | 2 500 | 2 800 | 112.0 |
| | Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 5 200 | 7 500 | 144.2 |
| | Алаг салат /шилтэй, Urbanek, 630 гр/ | 4 500 | 5 250 | 116.7 |
| 2. ШАТАХУУН | | | | |
| 1 | Бензин А - 80 | 2 040 | 2 480 | 121.6 |
| 2 | Бензин А - 92 | 2 070 | 2 500 | 120.8 |
| 3 | Дизелийн түлш | 2 690 | 3 760 | 139.8 |

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийг болон төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх мониторинг хийх зорилгоор “Глоб интернэшнл төв” ТББ-аас “Миний эрх миний гарт” төслийг хэрэгжүүлж уг төслийн хүрээнд “Бидний мэдэх эрх” сэдэвт сургалтыг манай аймагт зохион байгууллаа. Сургалтад төрийн албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн төлөөлөл нийт 30 хүн хамрагдсан.

“Иргэний шударга шүүх” ТББ-тай хамтран “Үндсэн хуулийн дугуйлан” төслийн сургалт арга хэмжээг аймгийн төр, төсвийн байгууллагын албан хаагчдад зохион байгуулж, тус төслийг хэрэгжүүлэгчдийн зүгээс Сэлэнгэ аймагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 11 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 165 /эрэгтэй-72, эмэгтэй-93/
 - Гэрлэлтийн бүртгэл - 41
 - Гэрлэлт цуцалсны бүртгэл - 19
 - Үрчлэлт - 4
 - Эцэг тогтоолт - 11
 - Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 12
 - Нас баралт - 65
 - Нийт олгосон иргэний үнэмлэх - 461
 - Шинээр олгосон иргэний үнэмлэх - 137
 - Дахин олгосон иргэний үнэмлэх - 102
 - Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч авсан - 222
 - Гадаад паспорт олголт - 2961
 - Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 168
 - Хот доторх шилжилт хөдөлгөөн - 146 тус тус бүртгэгдсэн байна.
- Газар өмчлөх, эзэмшиг, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-363
 - Анхны бүртгэл - 37
 - Өмчлөх эрх шилжих гэрээ - 71
 - Барьцааны гэрээ - 246
 - Бүртгэлд өөрчлөлт оруулах - 6

- Лавлагаа хуулбар - 1
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 113

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ /урьдчилсан байдлаар/

| Д/д | Үзүүлэлт | 2021.11 | 2022.11 | Өсөлт, бууралт | Хувь |
|-----|--|---------|---------|-------------------|-------------------|
| 1 | Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл | 3220 | 3997 | 777 | 24.1 хувиар өссөн |
| | Үүнээс: Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл | 1139 | 1517 | 378 | 33.2 хувиар өссөн |
| | Үүнээс: Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл | 2081 | 2480 | 399 | 19.2 хувиар өссөн |
| 2 | Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг | 593 | 733 | 140 | 23.6 хувиар өссөн |
| 3 | Нийт бүртгэгдсэн зөрчил | 20610 | 30500 | 9890 | 47.9 хувиар өссөн |

Архивын тасаг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны анхдугаар чуулган”-д төрийн архивын болон хөмрөг үүсгэгч байгууллагын архивын ажилтан зэрэг 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл оролцсон.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан Баянгол, Мандал сумдын Засаг даргын Тамгын газар, Хэрх, Түнхэл тосгоны Захирагчийн албанд Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

Төрийн архивын нягтлан шалгалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн албаны хөмрөгийн 1974-1992 оны 110 ХН-д нягтлан шалгалтын ажлыг хийсэн.

“ЗБИБ” ХХК-ий гүйцэтгэсэн Хүдэр сумын нутаг дэвсгэр дэх Хорооллын дундах зам засвар, “Сэлэнгэ ундрэм” ХХК-ий гүйцэтгэсэн Сүхбаатар сумын 3 дугаар багт баригдсан хүүхдийн тоглоомын талбай, 1 дүгээр багийн нутагт баригдсан цэвэр усны шугамын ажил, аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажил, 6 дугаар цэцэрлэгийн барилга засварын ажлын гүйцэтгэлийн баримт бичгийг хүлээн авч бүртгэл, акт үйлдсэн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Ирээдүйг Хамтдаа Бүтээцгээе” өдөрлөгийг аймгийн Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний газраас Сүхбаатар сумын ЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ “Best” хөтөлбөр, сумдын ЗДТГ, Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгууллаа.

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: “Сэлэнгэ аймгийн боловсролын салбарын байгууллагуудад зөвлөн туслах, аймгийн Засаг даргад хандан ирүүлсэн өргөдөл, гомдолд дүгнэлт гаргах, хянаж шалгах ажлын удирдамж”-ийн дагуу Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Сүхбаатар сумын

Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулиудад ажиллаж, хяналт шалгалт хийж, зөвлөн тусалж ажиллалаа.

Сүхбаатар сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд УИХ-ын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар, “Мобиком корпораци”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн дадлага ангид сургалтын тоног төхөөрөмж, сертификатыг гардуулж өгөх ёслолын арга хэмжээ амжилттай зохион байгуулсан.

“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ын дагуу ерөнхий боловсролын 35 сургуулийн 1333, сургуулийн өмнөх 40 байгууллагын 679 багш, удирдах ажилтан нийт 2012 албан хаагчийг цагаан хорхой, хеликобактери, дууны хөвч, бамбайн дааврын үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулж 100.788.120 сая төгрөгийг зарцууллаа.

Боловсрол, шинжлэх, ухаан, спортын сайдын А/340 тоот тушаалаар суралцагчийг халдварт болон халдварт бус өвчлөлөөс сэргийлэх зорилгоор хичээлийн жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж, сургуулийн 21953 сурагчдын 83,6 хувь хамрагдсаны 79.5 хувь нь өвчтэй гарсан бөгөөд өвчтэй сурагчдын 67,9 хувь нь, цэцэрлэгийн 7569 хүүхдийн 96,6 хувь хамрагдсаны 36.7 хувь нь өвчтэй гарсан бөгөөд өвчтэй хүүхдийн 85 хувь нь шүдний өвчтэй байна. Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын А/24 дугаар тушаалаар “Эрүүл мэндийг хянах карт”-ыг сургууль, цэцэрлэгүүд хүүхэд бүрд хөтлөн, багш, эцэг эхийг хүүхдийн өвчтэй байгаа тухай бүрд нь “Хүүхэд бүрийг эмчлүүлэн эрүүл болгох” чиглэл өгч ажиллан эрүүлжүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/461 тоот захирамжаар “Сэлэнгэ аймгийн сургуулиудын химийн кабинетад ашиглагдаж байсан хугацаа дууссан, хаяг шошгогүй химийн хорт болон аюултай бодисыг зайлуулах, тээвэрлэх, устгах” ажлын зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3.167.525 төгрөгөөр “Элемент” ХХК гүйцэтгэж 12 сургуулийн хугацаа дууссан, хаяг шошгогүй 42 л шингэн, 72 кг хуурай бодисыг устгуулсан.

“Судлагдахуун, суралцахууд суурилан, сургалтын чанарыг дээшлүүлэх” чиглэлээр 7-12 дугаар ангийн сурагчдыг химийн үелэх системийг ашиглах байдлын оношилгоонд үндэслэн хөгжүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 08-ны хооронд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 7-12-р ангийн 9087 сурагчийг тэдний насны онцлогт тохирсон арга, аргачлалаар сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Боловсролын орчин үеийн технологийн төв, Улаанбаатар хот дахь Оросын соёл, шинжлэх ухааны төв “Русский Дом” байгууллагаас зохион байгуулагдсан Орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад 19 багш хамрагдаж, мэргэжил арга зүйгээ дээшлүүлэв.

Бүгд Найрамдах Буриад Улсын Их Сургуулийн тэтгэлэгт улсын уралдаанд Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийн сурагч н.Нарансолонго, Сүхбаатар сумын Лаборатори 4 дүгээр сургуулийн орос хэлний багш Д.Мөнх- Учрал нар тэнцлээ.

“The 13th Jeju International Youth Forum-2022” буюу “Жэжү Олон улсын Хүүхэд Залуучуудын Чуулган-2022”-д Монгол Улсаа төлөөлөн Сэлэнгэ аймгийн багш, сурагчид 8 дахь жилдээ оролцлоо. Тус чуулган 3 дахь жилдээ цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд чиглүүлэгч багшаар Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн Англи хэлний багш Э.Оюумаа хариуцан, Сүхбаатар сумын Лаборатори 4 дүгээр сургуулийн 12-р ангийн сурагч Б.Солонго, Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12-р ангийн сурагч С.Энхжин, 11-р ангийн сурагч Ж. Төгөлдөр, Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн сурагч Б.Аминцэцэг нар амжилттай оролцсон.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Онцгой байдлын газраас хамтарсан “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ” цахим хурлыг зохион байгуулж, сумдын Засаг дарга, Тосгодын захирагч, багийн Засаг дарга, багийн нийгмийн ажилтнууд, цагдаагийн ажилтнууд, сум, тосгодын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, мэргэжлийн боловсролын байгууллагуудын захирлууд, мэргэжлийн боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд, сургуулийн сэтгэл зүйчид, эцэг эхийн зөвлөлийн төлөөллийг оролцуулан, хүүхэд хамгааллын талаар анхаарч ажиллах чиглэл өглөө.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/368 тоот тушаалаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ”-ний журмыг үндэслэн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ажлыг орон нутагт зохион байгуулж, сургалтад 35 сургууль, 38 цэцэрлэг хамрагдлаа.

2022 оны байдлаар боловсролын салбарын 99 байгууллагад суурин 1097, зөөврийн 1753, нийт 2850 компьютер, 616 хэвлэх төхөөрөмж, 202 хувилагч, 492 зурагт, 1753 хяналтын камертай бөгөөд интернэтэд 1563 компьютер холбогдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалуудыг үндэслэн цахим платформд суурилан зохион байгуулагдах багшийн мэргэшлийн болон мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтын модулийг Боловсролын ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/211 дүгээр тушаалаар баталсан бөгөөд батлагдсан модулиар Aplus платформ дээр сургалт зохион байгуулагдаж байна. Математикийн 90, физикийн 40, мэдээллийн технологийн 27 нийт давхардсан тоогоор 246 багш өөрийн хэрэгцээнд үндэслэн “Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих сургалтын модуль”-аас 21 сэдвээр давхардсан тоогоор 210 багш, “Багш, ажилтны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын модуль”-аас 7 сэдвээр 26, нийт давхардсан тоогоор 236 багш сонгон сургалтад хамрагдаж байна.

Өвөрхангай аймагт 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хөдөөгийн багш нарын спортын тэмцээн”-д манай аймгийн багш нарын баг Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр оролцож, 5 дахь удаагаа тэргүүлэн, цомын эзэн болсон.

Монгол Улсын Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу орон нутгийнхаа онцлогт тохируулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй соёл, урлагийн байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. Сарын аяныг дараах 3 чиглэлээр зохион байгуулсан.

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл
2. Бүх нийтийн соёлын боловсрол
3. Соёлын үйлдвэрлэл

Соёлын аялал жуулчлал сэдвээр 26 соёл, урлагийн байгууллагаас 300 гаруй ажил арга хэмжээ зохион байгуулж тайлан мэдээг удирдамжийн дагуу нэгтгэн хүргүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт 3237 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудын улсын тооллого хийгдсэн.

Монгол Улсын Соёлын яамны дэмжлэгтэйгээр, Монголын урлагийн ажилтны холбооноос уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн “Шилдэг бүтээл-шилдэг уран бүтээлч” төв, орон нутгийн мэргэжлийн чуулгуудын уралдаант наадам зохион байгуулагдаж, тус тэмцээнд мэргэжлийн 8 чуулгын 400 гаруй уран бүтээлчид оролцож 10 номинацид авьяас ур чадвараараа хүч сорин өрсөлдлөө. Уг уралдаанд Ардын дуу бүжгийн Сэлэнгийн Долгио Чуулга “Эрх чөлөөний цаана ...” шинэ уран бүтээлээр оролцож

“Шилдэг найруулагч” номинацид С.Баярсайхан,

“Шилдэг зураач” номинацид Б.Сайханбаяр,

“Шилдэг бүжиг дэглээч” номинацид Э.Ганзориг нэр дэвшин тэргүүн байр

“Шилдэг хөгжмийн зохиолч” номинацид Дэд байрыг Х.Алтангэрэл,

“Шилдэг гоцлол дуучин” номинацид Дэд байрыг гоцлол дуучин, МУСТА Л.Мөнхнаран,

“Шилдэг зураач” номинацид Дэд байрыг Д.Мөнхбат, нар тус тус эзэллээ.

Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн Футзалны тэмцээн Мандал суманд зохион байгуулагдаж, тэмцээнд 11-13 насны 11 баг, 14-16 насны 6 баг нийт 17 багийн 140 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдөж аваргуудаа шалгарууллаа.

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороо, түүний харьяа төвийн бүсийн спортын байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулсан спортын 5 төрөлт /волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, олс таталт/ тэмцээн Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж, тэмцээнд төвийн бүсийн Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Өмнөговь аймгууд оролцож багийн дүнгээр 1 дүгээр байр, шилжин явах Цомын эзэн боллоо.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/487 тоот захирамжаар “Жингийн илүүдэлгүй-Эртэч Сэлэнгэчүүд” сарын аяныг зохион байгуулж, Биеийн тамир, спортын газрын спорт заал, Усан спорт сургалтын төв, 7 сумын спорт цогцолборын /Алтанбулаг, Баянгол, Цагааннуур, Ерөө, Сайхан, Мандал, Баруунбүрэн/ нийт 1706 иргэн хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын газар, Ерөнхий Боловсролын Спортын сургууль, Ерөнхий Боловсролын 3 дугаар сургууль, “Барселон” олимпын зөвлөл, Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн хамтран зохион байгуулсан аймгийн Засаг даргын нэрэмжит “Аймгийн сургуулийн өмнөх

боловсролын багш, ажилтан, албан хаагчдын анхдугаар спортын тэмцээн"-ийг зохион байгуулж, тэмцээнд 38 цэцэрлэгийн 38 багийн 507 тамирчид оролцож, шилдгүүдээ шалгарууллаа.

Эрүүл мэндийн талаар: Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалын дагуу Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд 113,325 иргэн хамрагдахаас 11 дүгээр сарын байдлаар 21615 иргэн хамрагдаж, хамралтын хувь 19,1 хувь байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал суман дах Нэгдсэн эмнэлэгт насанд хүрэгчдийн буюу 18-аас дээш насны эрт илрүүлэгт 74586 иргэн хамрагдахаас 1783 иргэн хамрагдсан. Хамралтын хувь 3,4 хувь байна.

Насанд хүрэгчдийн 4 эрт илрүүлгийн багцад буюу

1. 18-30 насанд 21908 иргэнд хамрагдахаас 1364 иргэн хамрагдаж хамралтын хувь 6,2 хувь
2. 31-45 насанд 24774 иргэнд хамрагдахаас 566 иргэн хамрагдаж хамралтын хувь 2,3 хувь
3. 46-60 насанд 19074 иргэнд хамрагдахаас 436 иргэн хамрагдаж хамралтын хувь 2,3 хувь
4. 61-ээс дээш 8793 иргэнд хамрагдахаас 201 иргэн хамрагдаж хамралтын хувь 2,3 хувь байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллага буюу сум, тосгоны өрхийн эрүүл мэндийн төвд 0-17 насны 38739 хүүхэд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдахаас 19048 хүүхэд хамрагдаж хамралтын 49,2 хувь байна.

Эрт илрүүлгийг сайжруулах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн эрт илрүүлэг хамралт муу Хүдэр, Зүүнбүрэн, Орхонтуул, Рашаант, Дулаанхан тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хяналт үнэлгээ хийж хамралтыг 20-50 дахин нэмэгдүүлж ажилласан.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 тоот тушаалын дагуу Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтыг 1-12 нас, жирэмсэн эх, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, эрсдэлт бүлгийн хүнд хийхээр төлөвлөж, аймгийн хэмжээнд 13610 иргэн томуугийн дархлаажуулалтад хамрагдахаас 11412 иргэн буюу 84,7 хамрагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Тайлант хугацаанд Халамжийн санд улсын төсвөөс 74999 иргэнд 57975676.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 354 иргэнд 119509.0 мянган төгрөгийг олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх ажлын хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 34, идэвхтэй ажил хайгчаар 126, ажилд зуучлах үйлчилгээнд 76 иргэнийг хамруулж, сул чөлөөтэй 102 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 86 иргэнд үзүүлсэн байна.

Төр, хувийн хэвшил болон тусгай сангуудын эх үүсвэрээр тайлант хугацаанд шинээр 35 ажлын байр бий болгосныг Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээллээ.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэд, ажил олгогч байгууллагад сурталчлах, сул чөлөөтэй ажлын байрны захиалга авах, иргэдийг бүртгэн холбон зуучлах зорилго бүхий “Эмэгтэйчүүдийг цагийн ажилд зуучлах өдөрлөг”-ийг зохион байгуулж, өдөрлөгийн үеэр хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний талаарх мэдээлэл зөвлөгөөг 100 гаруй иргэнд өгч ажиллалаа. Тус өдөрлөгийн үйл ажиллагаанд “Бороо гоулд” ХХК, “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ, “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК, “Алтан тариа” ХХК, ХААН банк оролцож, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас нийт 150 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлж, тэдгээрт тохирох ажил хайж буй 47 иргэнийг зуучиллаа.

Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэх хүрээнд мэргэжлийн ур чадвартай 9 ахмад мэргэжилтнээр боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй, мал аж ахуй, газар тариалан, цаг уурын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгч, эдгээр ахмад мэргэжилтнүүдэд нийт 8271.0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 4,314,253,400 төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төлөвлөгөөгөөр 39755531,52 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулахаас 45700691,88 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 114,95 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18654 тэтгэвэр авагчдад 110055983 мянган төгрөгийг, тэтгэмжийн даатгалын сангаас 6522 даатгуулагчдад 328529 мянган төгрөгийн ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 215 даатгуулагчид 1065654 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд тус тус олгосон.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 604 даатгуулагчдад 1211695 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын 1995-2005 оны 351 лавлагааны хүсэлтийг хүлээн авч 347 лавлагааг гарган хүргүүлж, аймаг дотроо 575 иргэд даатгуулагчаас лавлагааны хүсэлтийг авч нийт 926 лавлагааг гаргаж ажиллалаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь тус сард 4 удаа хуралдаж нийт 308 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 35 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 16 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 260 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын удирдамж дагуу Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3 сургууль, 2 цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 11 дүгээр сарын байдлаар нийт 19 дуудлага ирснээс Түшиг 1, Ерөө 1, Жавхлант 1, Мандал 6, Сүхбаатар 5, Орхонтуул

1, Зүүнбүрэн 1, Цагааннуур 1 /сумдад/ тус тус бүртгэж хамтарсан багуудад шилжүүлж ажиллалаа.

Зорилтод бүлгийн 30 залуугийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах удирдамжийн дагуу зорилтод өрх гэр бүлийн гишүүдэд “Гэр бүлийн харилцаа”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр сургалт зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.

“Тэгш боломжийн төлөө Залуучуудын манлайлал” сургалтын хөтөлбөрийн хүрээнд Шаамар, Сүхбаатар, Зүүнбүрэн сумын 282 сурагч, МСҮТ-ийн 40 суралцагч, Зүүнбүрэн сумын 130 гаруй эцэг эхэд сургалт нөлөөллийн ажил зохион байгууллаа.

Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Угийн бичиг хөтлөх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/221 дүгээр тушаал “Ураг удмын алтан хэлхээ” бүсчилсэн сургалтыг ирээдүй хойч үедээ өв соёлоо уламжлан үлдээх, хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор Угийн бичгийн академийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран Орхонтуул, Мандал суманд тус тус зохион байгууллаа. Сургалтад иргэдийн төлөөлөл, ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл, багийн нийгмийн ажилтнууд, Зүүнхараа хүүхдийн ордны ажилтан, нийт 100 хүн оролцож, “Ураг удмын алтан хэлхээ” сэдэвт илтгэл, ханын самбар, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж, нийт 42 материал ирүүлснээс шалгарсан оролцогчдын шагналыг гардууллаа.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр насанд хүрэгч 2, 3 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээг 1-4 удаагийн давтамжтай үзүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн 28 сурагчдад бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, хорих ял эдэлж байгаа 9 иргэнд зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн сургалтыг, мөн арга хэмжээ авагдсан 4 хүүхэд, биеэр ял эдэлж байгаа 3 насанд хүрэгчдэд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө оношилгоог хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэлээ.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар: 2022 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр үр тариа 136.9 мянган га талбайд тарьж, 3.6 мянган га талбайд ургац алдаж, 1.5 мянган га талбай тэжээлд шилжиж, 131.7 мянган га талбайгаас 14 цн буюу 183.9 мянган тн ургац авснаас 125.2 мянган га талбайгаас 14,2 цн буюу 177.8 мянган тн улаан буудай, 682 га талбайгаас 748 тн арвай, 4866.9 га талбайгаас 4484.9 тн овьёос, 945 га талбайгаас 823 тн гурвалжин будаа, 15999 га талбайгаас 27955 тн тэжээлийн ургамал, 49397 га талбайгаас 23587 тн тосны ургамал, 2374 га талбайгаас 30686 тн төмс, 3597.2 га талбайгаас 52727.8 тн хүнсний ногоо хураан авсан.

Хөдөө аж ахуйг дэмжин санд 16.1 мянган тн, гурилын үйлдвэрт 64.1 мянган тн, тэжээлд 30.8 мянган тн, спиртэд 5.5 мянган тн буюу нийт 116.6 мянган тн улаан буудайг борлуулж, өөрийн үрд 17.0 мянган тн нөөцөлж, 61.2 мянган тн борлуулагдаагүй үлдсэн байна.

“Хөдөлмөрийн үр шимийн баяр”-ын арга хэмжээг Сүхбаатар суманд зохион байгуулж, нийт 324 хүнс, хөдөө аж ахуйн салбарын төлөөллийг оролцуулж, аймгийн газар тариалангийн салбарын шилдэг 18, “Тэрбум мод” үндэсний

хөдөлгөөнд идэвх санаачилгатай ажилласан 6 байгууллагыг тодруулж, 27 Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүнд батламж олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын “2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 02 тоот албан даалгавар гарган хэрэгжилтийг ханган хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах үүрэг чиглэлийг сумдад өгч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

2022 онд аймгийн хэмжээнд 17 сумын 56 багийн 9519 малчин болон мал бүхий өрхөд 1,9 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээг авч, малчид зун, намрын улиралд хол ойрын оторт гарч мал сүрэгтээ тарга хүч авхуулах ажлыг зохион байгуулснаар мал сүргийн 97 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүч аваад байна. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт 60,1 мян.мал бүхий 191 өрх өвөлжихөөр байна.

Отор нүүдлээр Зүүнбүрэн, Жавхлант, Орхонтуул, Сайхан, Мандал сумдад 5 аймгийн 61 өрхийн 30,0 мянган толгой мал орж ирсэн.

Хадлан бэлтгэх ажилд аймгийн хэмжээгээр механикжсан салаа 45, хадлангийн бага оврын тракторын иж бүрдэл 450, ажиллах хүч 3200 ажиллаж, 131,0 мянган тн байгалийн хадлан, 46,5 мянган тн хүчит тэжээл, 5,8 мянган тн эрдэс тэжээл бэлтгэхээс 150,6 мянган тн өвс, 4,6 мянган тн сүрэл, 11,6 мянган тн ногоон тэжээл, 35,6 мянган тн үйлдвэрийн тэжээл, 6,6 мянган тн дарш, 701 тн гар тэжээл, 5,4 мянган тн эрдэс тэжээл бэлтгэсэн нь малчин болон мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг 104,7 хувьтай бэлтгээд байна.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс “Алтан тариа” ХХК-тай цаг хүндэрсэн үед малчдад 30 тн тэжээлийг нийлүүлэхээр гэрээ байгуулаад байна. Сумдын нөөцөд 1360 тн өвс, 680 тн тэжээл бэлтгэхээс 1082 тн өвс, 495 тн тэжээл бэлтгэсэн нь 76,2 хувьтай байна. Мөн өөрийн аймгийн болон гадны аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн хэрэгцээ болоод бизнесийн зориулалтаар 5,6 мянган тн өвс бэлтгэсэнээс 3,3 мян.тн-ыг борлуулж 11 дүгээр сарын байдлаар үлдэгдэл 2,3 мянган тн өвс байна.

2022 оны өвөлжилт, хаваржилтаар 97,1 мянган толгой мал байнгын, 412,9 мянган мал нэмэгдэл тэжээлтэй өвөлжих бөгөөд эдгээрт шаардагдах тэжээлийг бэлэн байгаа тэжээлтэй харьцуулахад тэжээлийн хангамж 100 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 110,9 сая тн бүхий тэжээл бэлтгэсэн нь нэг хонин толгойд 32.4 т.нэгж ноогдож, нийт малыг 50-60 хоног нэмэгдэл тэжээлээр тэжээхэд хүрэлцэхүйц нөөц юм.

2022-2023 оны өвөл хавар бэлчээрт 3993 инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг ашиглагдах бөгөөд худгийн бэлэн байдал 97,9 хувь, өрхийн усан хангамж 97,3 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд мал өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг 96,1 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авлаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/68 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/168 тоот захирамжийн хүрээнд Газар тариалангийн бүс болох Сэлэнгэ аймгийн 16 сумын нутагт үржүүлж байгаа 124480 толгой мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох,

баталгаажуулах, үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, үхэр сүргийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан хавар намрын технологит ажлаар нийт 124480 толгой малд үзлэг ангилалт хийснээс цөм сүрэгт 8.8 хувь буюу 11004 толгой, үржлийн сүрэгт 22.5 хувь буюу 27008 толгой, хэрэгцээний сүрэгт 69.4 хувь буюу 86468 толгой малыг тус тус хамруулсан байна.

Аймгийн хэмжээнд 17 сумын үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч 1000 толгой адуу, 26000 толгой үхэр, 9000 толгой хонь, 5000 толгой ямаа нийт 41000 толгой малыг ялган тэмдэглэж, ээмэгжүүлэн 11 дүгээр сарын байдлаар 73 толгой адуу, 6195 толгой үхэр, 1394 толгой хонь, 116 толгой ямаа нийт 7778 толгой малын мэдээллийг “Малын мэдээллийн нэгдсэн сан” /livestock.mofa.gov.mn/-д бүртгэлжүүлэн ажилласан байна.

Монгол Улсад хоршоолох хөдөлгөөн үүссэний 100 жилийн ой, Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Сэлэнгэ таван хайрхан” дундын хоршоо болон түүний гишүүн хоршоод үйл ажиллагаагаа сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, орон нутагт хоршооны тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Сант суманд өдөрлөг зохион байгуулж, “Органик бүтээгдэхүүний дээжис” үзэсгэлэнг гаргасан.

“Хөгжлийн шийдэл” ТББ тай хамтран “Хоршоо хөгжүүлэх сангийн шинэчилсэн журмын талаарх сургалт”-ыг 17 сумын Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Хоршоо хөгжүүлэх сангийн шинээр байгуулагдсан сонгон шалгаруулах болон хяналтын зөвлөлийн гишүүдэд нийт 204 хүнийг хамруулан зохион байгуулж, чанаргүй зээлийн эргэн төлөлт сайжирч, чанаргүй зээлийн хэмжээ 45,0 сая төгрөгөөр багассан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Аймгийн Засаг даргын 2022 оны А/197, А/191, А/388 захирамжаар Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулж, нийт 328.5 мянган толгой мэдрэмтгий мал, амьтан хамруулахаас 6976 өрхийн 318.2 мянган үхэр, 437 өрхийн 9.9 мянган гахай нийт 328.2 мянган толгой мал, амьтныг 100.0 хувь хамруулсан.

Адууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 32.0 мянган толгой адуу хамруулахаас нийт 798 өрхийн 31.9 мянган толгой адууг холбогдох заавар, журмын дагуу технологит хугацаанд нь 99.9 хувь хамруулсан.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 5.2 сая толгой мал, амьтан хамруулахаас давхардсан тоогоор 5.3 сая толгой мал, амьтан буюу 100,3 хувийг хамруулж, угаалгад 1.6 сая толгой, туулгалтад 1.8 сая толгой, боловсруулалтад 1.5 сая толгой, арьсны гуурын боловсруулалтад 241.7 мянган толгой үхэр, нохой, муурын үржил таслах ажилбарт 710 нохой, муур тус тус хамрагдсан.

Мал эмнэлгийн нэгдсэн системд гарал үүслийн 4897 гэрчилгээгээр хүнсэнд 408 адуу, 2210 үхэр, 2857 хонь, 1366 ямаа, 49 гахай буюу нийт 6890 толгой мал, амьтан, 811.3 мянган кг мах, махан бүтээгдэхүүн, 1.5 сая кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 1563 ш арьс шир, 17941 кг түүхий эд буюу нийт 2.4 сая кг ширхэг бүтээгдэхүүний гарал үүсэл, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хянан баталгаажуулсан. 210 гарал үүслийн гэрчилгээгээр 1590 адуу, 1301 үхэр, 8174 хонь, 3105 ямаа, 43 гахай, 102 тэмээ буюу нийт 14 мянган толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн удирдамжийн дагуу 2 хонины мах, 2 ямаа мах, 1 адууны мах, 1 үхрийн мах, 2 өлөнгөөс дээж авч малын эмийн үлдэгдлийн хяналт, шинжилгээнд хамруулахаар хүргүүлсэн.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос хийсэн “Хээлтүүлэгч малд бруцеллёзын тандалт-2022” гэрээний дагуу нийт 8556 хээлтүүлэгч малыг бруцеллёзын шинжилгээнд хамруулахаас бух 2209, ухна 2840, хуц 3502, буур 5 буюу 100 хувийг хамруулж, бух 3, хуц 4, ухна 3 эерэг дүнтэй гарсныг баталгаажуулж, мал эмнэлгийн ахлагч байцаагчаар дүгнэлт гаргуулан хариуг сумдад өгч хэрэгцээлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын малаас шимэгч судлалын лабораторид 45 дээжид гельминтийн өндөг тоолох шинжилгээ хийсэн.

Байгаль орчин, Ус, цаг уурын талаар: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу Ойн нөөц ашигласны төлбөр 5.0 тэрбум төгрөг, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 893.9 сая төгрөг, байгалийн ургамал ашигласны төлбөр 14.1 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 9.2 сая төгрөг нийт 5 тэрбум 917,2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 55 дугаар тогтоолоор 2022 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 33 арга хэмжээг 1 тэрбум 460 сая төгрөгийн ажил хийхээр батлуулж, 100 хувь зарцуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

2023 оны мод бэлтгэлийн саналыг аймаг, сумын ойн менежмент төлөвлөгөөтэй харьцуулан нийт 17 суманд 190643 м3 бэлтгүүлэхээр санал хүргүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/437 дугаар захирамжаар Алтанбулаг, Мандал, Хүдэр, Ерөө, Сүхбаатар сумдад ойжуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг байгуулж, 9 аж ахуй нэгж, байгууллагын намрын ойжуулалтын ажлын явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Мөн 13 аж ахуй нэгж байгууллагын хаврын ойжуулалтын ажлыг 381,5 га-д 431 хүний бүрэлдэхүүнтэй 1 га-д 475-2500 ширхэг шон татаж царил ашиглан хэсэг талбайд хүрээр тогоолон 2*2 -6*3,5 схемтэй нарс 570.2 мянган ширхэг, шинэс 141.9 мянган ширхэг, бусад төрлийн мод 221.1 мянган ширхэг нийт талбайд 933.2 мянган ширхэг навчит болон шилмүүст модыг тариалж 67,7 хувийн ургалттай хүлээн авсан.

Мандал сумын 5 дугаар баг “Хар модот”, “Шар шалга”-ын 160 га талбай, Орхон, Орхонтуул, Сүхбаатар суманд тус бүр 5 га талбайд ойн зурвас, Орхонтуул сумын “Замын булаг” нэртэй газарт замын булгийн усыг хуримтлуулах, хөв, цөөрөм барих ажлыг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, “Сэлэнгэ ундрэм” ХХК шалгаран хөв цөөрөм байгуулсан.

НҮБ-ын Байгаль Орчны Сангийн сумын хог хаягдлыг бууруулах жишиг тогтолцоог бүрдүүлэх төсөлтэй хамтран “Хог хаягдлын менежмент, дахивар нөөцийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай сургалт”-ыг зохион байгуулж, 17 сум 6 тосгоны 100 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр мэдлэг олгосон.

“Дендрологич-Мод хэлбэржүүлэх арга технологич бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулж, аймгийн хэлтэс, агентлагуудын төлөөлөл 70 гаруй албан хаагчдыг оролцуулан мод үржүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгийн суулгац ургуулах, цэцэрлэгжүүлэлттэй холбогдолтой стандарт, ногоон байгууламжийн ангилал, тэдгээрийн төлөвлөлтийн онцлогийн талаар мэдлэг олгосон.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 77 аж ахуйн нэгжийн 2596.62 га газар нь бусдын эзэмшил, өмчлөл, ашиглалтын газартай давхцал үүсгэсэн зөрчлийг арилгаж, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн, газар эзэмших гэрээ байгуулж, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулан ажиллах талаар чиглэлийг хүргүүлсэн.

Ерөө сумаас Бугант тосгон хүртэлх чиглэлийн авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл, Мандал сумын 6-р баг, Депо-8-819 тоотод байрлах “Шунхлай петролиум” ХХК-ий ШТС-ын гадна цахилгаан хангамж, Алтанбулаг сум, Алтанбулаг чөлөөт бүс “Эко фрукт чөлөөт бүс” ХХК-ий дэлгүүр агуулахын барилга, “Төгс төгөлдөр Эрдэнэ” ХХК-ий “Дэлгэрхан ресорт” спорт заалны барилга, Мандал сумын иргэн О.Алимаагийн үйлчилгээний барилга, Сүхбаатар сумын нөхөн сэргээх, хүүхэд хөгжил, сургалтын төвийн барилгын ус хангамж ариутгах татуургын зураг төсөл, Мандал сумын төвийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, Орхонтуул сумын 1-р баг, Рашаант тосгоны Хонхор 2, 7, 8 дугаар гудамжны гэрэлтүүлэг, Мандал сумын иргэн Д.Туяагийн “Хүдэр боловсруулах үйлдвэрийн гадна цахилгаан хангамж, Зүүнбүрэн сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн барилгын зураг төсөв хянасан.

Алтанбулаг сумын Алтанбулаг чөлөөт бүс “Жагро Тех чөлөөт бүс” ХХК, “Экофрукт чөлөөт бүс” ХХК-иудын үйлчилгээний барилга, “Төгс төгөлдөр Эрдэнэ” ХХК-ий “Дэлгэрхан ресорт”-ийн спорт заалны барилга, Сүхбаатар сумын Салхит 3 дугаар багт багийн байр барих ажлын архитектор төлөвлөлтийн даалгавар боловсруулсан.

Аймгийн хэмжээнд тохижилт, ногоон байгууламж, барилга байгууламж, авто зам, авто зогсоол, автобусны зогсоол, төмөр замын өртөө, авто тээврийн төвийн мэдээллийг зурж, бүртгэн shp зургийг ArcGis програм дээр зурж Urban manager системд оруулан 100 хувь бүртгэж дуусгасан.

Сүхбаатар сумын 4-р баг, 200 ортой хүүхдийн цэцэрлэг, Цагааннуур сумын “Тамгат нуур” ХХК-ий ШТС, Алтанбулаг сумын “Алтанбулаг ирээдүй чөлөөт бүс” ХХК, “Монгол алтай индастри чөлөөт бүс” ХХК-иудын худалдаа нийтийн үйлчилгээний газар, Мандал сумын “Мал угаалгын ванн”, “Хайрган хучилттай зам засвар”, “Тоглоомын талбай”, 1, 2, 4, 6, 9-р багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, Орхонтуул суманд “Хөв цөөрөм”, Сүхбаатар сум, 7-р багийн нутаг дэвсгэрт “16 айлын орон сууцны засвар”-ын ажилд барилга угсралтын болон засварын ажилд ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.

Алтанбулаг сумын 3-р багийн “Хяраан гол гүүр”, Түшиг сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Сайхан сумын Хавцал дах “Сортоо үр” ХХК-ий усалгаатай талбайн цахилгаан хангамж, Жавхлант сумын Хатуу хучилттай авто зам барих, Цагааннуур сумын “Мөнх өсөх залгамж” ХХК-ий шатахуун түгээх станцын гадна цахилгаан хангамж, Мандал сумын иргэн Б.Гантулгын амины орон сууцны гадна

цахилгаан хангамж, Сүхбаатар сумын иргэн Д.Оч-эрдэнийн Граж агуулах бүхий сэндвичин барилга байгууламж, иргэн Б.Энхцэцэг авто засварын газар, барилга байгууламж, Цэвэр усны шугам татах ажил, Бохирын шугам татах, Орхон сумын халаалтын шугамын өргөтгөл, Цахилгаан хүчдэл нэмэгдүүлэх, Сайхан суманд зам талбайн тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлэх, Овоот, Дөмбөн хорооллын авто замыг хатуу хучилттай болгох ажил, Орхон сумын Дулааны шугам тавих, Орхонтуул сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажлуудыг хийсэн.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Засгийн газрын 359 дүгээр тогтоолын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 14 төсөл арга хэмжээний эрх шилжин ирснээс 17,271,858,000 төгрөгийн 13 төсөл арга хэмжээний тендер зарлагдахаас 5 ажлын төсөв татагдаж, ажлын явц 100 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,525.55 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, 92.3 хувьтай, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 2,364.0 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, 92.3 хувьтай, замын сангийн хөрөнгөөр 1 тендер зарласан ажил 100 хувьтай, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар санхүүжигдэх 1 төсөл арга хэмжээний ажлын даалгавар, хяналтын төсөв ирээгүй тул зарлагдаагүй байна. Мөн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 1.028 сая төгрөгийн 8 ажил зарлагдаж, 100 хувийн гүйцэтгэлтэй, нийт 4 ажлын техникийн даалгавар, зураг төсөв ирээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/155 тоот захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/40 тоот тушаалын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого 100 хувь дууссан ба өнөөдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тооллоготой холбоотой бичмэл тайлан, зарим дүн мэдээг залруулга хийж баталгаажуулах ажлыг хийсэн.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын Засаг даргын 2022 оны А/92 тоот “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөнийг өрнүүлэх тухай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн албан хаагч бүрийн үндэсний бичгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх хуулиар олгогдсон эрх боломж, нөхцөлийг хангах, 2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан “Байгууллагын хичээнгүй бичигтэн” , Байгууллагын түргэн уншигч уралдаанд сумын Засаг даргын албан хаагчдын хооронд амжилттай зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цөх гуравдугаар багт 592,0 сая төгрөгөөр Хяраан голын гүүрийг барих ажлыг “Хайвэй интернэшнл групп” ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлцлээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд хүүхэд, багачуудад үндэсний бахархал болох өв соёлоо дээдлэх, эх түүх монгол

ахуй соёлыг түгээн дэлгэрүүлэх тодорхой мэдлэг мэдээлэлтэй болоход зориулан аймгийн Нэгдсэн музейтэй хамтран “Монгол ахуй” музейн боловсролын хөтөлбөрт хичээлд 3-8 дугаар ангийн 412 сурагч хамрагдсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулсан “Ногоон гэрэл-Цагаан шугам 2022” тэмцээнийг Ерөнхий боловсролын 3-5 дугаар ангийн дунд зохион байгуулж, Ч.Тамиртүшиг багштай “Бүргэдэй” тасаг оролцож “Шилдэг зохицуулагч”-аар багийн ахлагч О.Лхагва-Эрдэнэ шалгарсан.

Баруунбүрэн сум:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 эм хонинд баяд үйлдвэрийн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, 2022 оны хавар зохиомол хээлтүүлэг хийсэн үхрийн 20 хувь буюу 25 үхэрт хээлтийн шалгалт хийхэд ажлын үр дүн 90 хувьтай байна.

Иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд тус сумаас түлшний мод бэлтгэдэг Орхон, Орхонтуул, Сайхан сум, Номгон тосгоны иргэдийн мод бэлтгэлийн ажил явагдаж байгаатай холбогдуулан хууль бус мод бэлтгэлтэй холбоотой эргүүл шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Тус суманд ойн үйл ажиллагаа эрхлэгч “Шинэ-орос хийц” ХХК-д 50 га, Сант суманд 21 га, Хушаат сумын “Тогосын нарс” ХХК-д 6 га талбайд талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас улсын хэмжээнд тоон гарын үсгийг иргэдэд олгож эхэлсэнтэй холбогдуулан сумын хэмжээнд 11 дүгээр сард нийт 85 иргэнд, өссөн дүнгээр 307 иргэнд олгосон байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 (Хорин сая төгрөг)-ийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн Биеийн тамирын заалны их засварын ажил 40 хувьтай явагдаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөл хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн Олон Улсын өдөр”-ийг зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл хийж, Эрүүл мэндийн төвөөс эрт илрүүлгийн үзлэг, “Зуун наст” эмийн сангаас иргэдийг витаминжуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд даам, дардас, караоке тэмцээн, хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байуулан шагнаж урамшууллаа. “Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн Олон Улсын өдөр”-ийг зохион байгуулахад сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд хүнсний бүтээгдэхүүн болон мөнгөн тусламж үзүүлж хамтран ажиллалаа.

Сумын Соёлын төвөөс “Соёлын сар” нэгдсэн арга хэмжээг нээж иргэдэд сурталчлан “Намрын уянга-2022” нийтийн дууны наадмын 1 дүгээр үе шатыг 6-12 нас, 13-17 нас, насанд хүрэгчид гэсэн 3 ангиллаар зохион байгууллаа. Уг наадамд нийт 18 ардын авьяастан, хүүхэд багачууд оролцлоо.

Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, иргэн, гэр бүл, хамт олонд эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны “Жингийн илүүдэлгүй-эртэч Сэлэнгэчүүд сарын аяныг зохион байгуулах тухай” А/487 тоот захирамжийн дагуу сумын иргэдэд цахим хуудсаараа дамжуулан сурталчлан ажиллаж төр, төсвийн байгууллагын албан хаагчид болон иргэд аянд

идэвхтэй хамрагдаж байна. 11 дүгээр сард давхардсан тоогоор 450 гаруй иргэн Спорт цогцолбороор үйлчлүүлж идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж байна.

Баянгол сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны 01/1416 тоот албан бичгийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон Улсын тэмдэглэлт өдрүүдийг угтан орон нутгийн хэмжээнд “Ирээдүйнхээ төлөө бид хамтдаа” өдөрлөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулж, өдөрлөгт нийт 70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдлаа.

Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадал сургах, аюулгүй байдлаа хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон явуулдаг “**Ногоон гэрэл- Цагаан шугам 2022**”, “**Бид Өсвөрийн Сэргийлэгчид**” тэмцээн Мандал сумын “Мөнгөн хараа” дуу бүжгийн чуулгад зохион байгуулагдаж 3-5-р ангийн 8 хүүхэд, 2 багш оролцлоо.

Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга нарын хамтарсан 2022 оны А/153, А/139, А/170, А/28, А/58 дугаар тушаалаар батлагдсан “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн аяны хүрээнд “Хамгаалагдсан хүүхэд” төлөвлөгөөний дагуу Цагдаагийн хэсэгтэй хамтран 20:00-22:00 цаг хүртэл эргүүлийг гүйцэтгэж байна.

Сумын хэмжээнд Хараа, Баян, Гонир багийн иргэдийн Нийтийн хуралдааныг “Вектор мэл” ХХК-тай хамтран зохион байгуулж, хуралдаанд 125 иргэн оролцож сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний төслийг хэлэлцлээ.

Орон нутаг судлах танхимаас үндэсний бахархал, өв уламжлал, түүх соёлоо сурталчлах зорилгоор Чингис хааны эш хөрөг залах, ахмадуудын дунд “Шагайн наадгай” тэмцээн, “Монгол бахархал” хайчилбар, “Эх хэл бичиг мину” монгол уран бичлэгийн үзэсгэлэн, сургалт, “Баянголын соёлын үйлдвэрлэл” үзэсгэлэн, цахим мэдээлэл, “Бүтээлч сэтгэлгээ, ур чадвар” үзэсгэлэн, номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, уншигчдын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Танайд хүрч үйлчилнэ” нүүдлийн номын сангийн үйлчилгээ, “Хамтдаа уншъя” чанга уншлага, “Ном дотор гэгээрэл бий” Сэлэнгийн зохиолчдын уулзалт, “Номын сайн нөхөр” хүүхдийн номын үзэсгэлэн, “Угийн бичгээ хөтөлж, ураг төрлөө дээдэлье” мэдээллийн арга хэмжээ 3 удаа, “Баянголын алтан намар” гар зургийн уралдааныг тус тус зохион байгууллаа.

Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд зарын дагуу нэг аж ахуй нэгжээс төсөл ирүүлснийг хэлэлцэж 60,0 сая төгрөгийн зээлийн олгоод байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар “Бэсүжин констракшн” ХХК сумын төвийн уурын зуухны шинэчлэлийн ажилд ОХУ-аас чанарын шаардлага хангасан 200 сая төгрөгийн зуухыг нийлүүлсэн.

Ерөө сум:

Сумын Засаг даргын 2022 оны 247 дугаар захирамжийн хүрээнд Ерөөгийн бүсийн төрийн албан хаагчдын нөхөрсөг уулзалт, тэмцээнийг зохион байгуулж, Ерөө, Жавхлант, Хүдэр сум, Бугант тосгоны нийт 87 төрийн албан хаагч спортын

5 төрлийн тэмцээнээр өрсөлдөн шилжин явах цомын эзнээр Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын баг хамт олон шалгарлаа.

Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор “Цыга” үүлдрийн хуцын үрээр Ерөө үүлдрийн хэсгийн хонь өсгөн үржүүлж буй 8 өрхийн 558 хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг хийлээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тухайн жилийн төлөвлөгөөний дагуу 1 байршлын 15 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар 1 төрийн байгууллагад эзэмшүүлэн гэрээ, гэрчилгээ олгосон.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллага болох “Лэнд овнер” ХХК-ий ажлын хэсэгтэй багийн Засаг дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж өвөлжөөний байршлуудыг зурагт тэмдэгжүүлж, бүсчлэлийн саналыг гаргасан.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төсөл сонгон шалгаруулах хороо, хяналт тавих орон тооны бус зөвлөлийн 10 гишүүнд хоршоог дэмжих сангийн журмын танилцуулга хийж, сонгон шалгаруулалт, хяналт шалгалтыг хийх тухай заавар зөвлөгөө өглөө.

Хоршоог дэмжих сангийн үйл ажиллагаанд Хяналт тавих орон тооны бус зөвлөлөөс чанаргүй 27 зээлдэгч, муу зээлийн ангилалд орсон 12 зээлдэгчид хяналт шалгалт хийж, 9 зээлдэгчдтэй биечлэн уулзаж зээлийг хэрхэн үр дүнтэй зарцуулсан байдалтай танилцаж, мэдэгдэх хуудас өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/388 тоот захирамж, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/191 дүгээр тушаал, сумын Засаг даргын А/205 дугаар захирамжийн хүрээнд 502 өрхийн 21995 толгой үхэр, 56 өрхийн 705 гахай нийт 558 өрхийн 22700 толгой мал амьтан тус тус хамруулсан.

Ерөө сум нь нийт газар тариалангийн 23454,66 га эргэлтийн талбайтай. 2022 онд 16 үр тарианы аж ахуйн нэгж, 14 иргэн нийт 16471 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 12822 га талбайгаас 23079 тн ургацын дундаж нь 17.9 цн, рапс 2761 га талбайгаас 1086 тн ургацын дундаж нь 3.9 цн, арвай 48 га талбайгаас 38 тн ургацын дундаж 8 цн, овьёос 92 га талбайгаас 111 тн ургацын дундаж нь 12.06 цн, ногоон тэжээл 617 га талбайгаас 534 тн ургацын дундаж нь 8,6 цн тус тус хураан авсан.

1,2,3-р багийн 304 иргэн, 9 хоршоо төмс 67.2 га талбайд тариалалт хийж 915.6 тн ургацын дундаж 136.2 цн, хүнсний ногоо 85.4 га талбайд тариалалт хийж 711.16 тн ургацын дундаж 83.2 цн тус тус хураан авсан.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу байгууллагын дарга нар төрийн албан хаагчид оролцсон 10 хэсэг, сумын төвийн айл өрхөөр нэг бүрчлэн орж, өвөлжилтийн бэлгэл ажил, Жавхлантын мэдээ сонин, цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэх, иргэдийн санал бодлыг сонсох, Төр төсвийн байгууллагууд болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын талаар үнэлэлт дүгнэлт авах, санал хүсэлтийг сонсох зорилгоор ажиллалаа.

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3.5.8 заалтад тусгагдсан Хөдөөгийн малчдын гар утасны үүрэн холбооны сүлжээг сайжруулах малчдын цахим хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Юнител” компанид хүсэлт уламжилсны

дагуу Моностой 2 дугаар багийн Эрдэнэ ууланд юнителийн 4G сүлжээг бүрэн ашиглалтад оруулан нэвтрүүллээ.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газраас хамтран Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумын нийт иргэд, малчин, мал бүхий иргэдийн дунд уулзалт, ярилцлагын арга хэмжээ зохион байгууллаа.

Соёлын сайдын 04 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэн “Хүүхэд хөгжил хамгаалал” өдөрлөгийг зохион байгуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 159 дүгээр зарлигийн дагуу Эзэн богд Чингис хааны эш хөргийг Өв соёлын өргөөнд хүндэтгэн заллаа.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 16500 тун вакцин татан авч сумын хэмжээнд 16286 үхэр, 138 гахайг тус тус вакцинжуулалтад хамруулаад байна.

Зүүнбүрэн сум:

“Монгол бахархал”-ын өдрийг тохиолдуулан Монгол Улсын “Иргэний Андгай” өргөх ёслолын арга хэмжээг Иргэний нээлттэй танхимд зохион байгуулан шинээр иргэний үнэмлэх авч буй 36 иргэн “Андгай” өргөж төрийн албаны шалгалтад тэнцсэн 2 албан хаагч тангараг өргөлөө. 11 сарын байдлаар 610 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Орон нутагт малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын А/187 тоот захирамжаар байгуулан ажиллаж 401 өрх 1 аж ахуйн нэгж байгууллагын 15800 толгой бод мал, 600 толгой гахайг дархлаажуулалтад хамрууллаа.

Сумын цагдаагийн албатай хамтран Булган аймгийн Хангал сумаас 90 үхэр 6 адууг тээвэрлэн яваа 2 авто машиныг саатуулан шалгаж гарсан зөрчлийг арилгаж ажиллалаа.

“Хоггүй, цэвэрхэн Зүүнбүрэн аян”-ны хүрээнд нийтийн эзэмшлийн газруудыг хогийг цэвэрлэн 5 тн хог хаягдлыг устгалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд иргэдийн түлээ, нүүрс бэлтгэх ажлыг холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж “Улаан овоо”-ны нүүрсний уурхай өрх бүрт 2 тн нүүрс хөнгөлттэй үнээр олгохоор сумын Засаг даргатай гэрээ байгууллаа.

Мандал сум:

Зүрхний төрөлхийн болон олдмол эмгэгтэй хүүхэд, насанд хүргэгчдэд амьдрал бэлэглэх зорилготой 13 эмчийн бүрэлдэхүүн бүхий “Хязгаараас чинад” төслийн багийнхан Мандал суманд ажиллаж **714** хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, зүрхний хагалгаанд 28 хүүхэд, 10 том хүн нийт 38 хүн орохоор боллоо.

Бүгд Найрамдах Солонгос Улсын “Нам Сөүл” Хөдөө Аж Ахуйн Их Сургууль Мандал сумын ерөнхий боловсролын Хэрх сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Солонгос хэлний “Зөгий” сургалтын төвөөр дамжуулан Хэрх сургуулийн сурагчдад Солонгос хэлний сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтад одоогоор 39 сурагч хамрагдаж байгаа ба цаашид бусад сургуулийн сурагчдыг хамруулан, үйл ажиллагаагаа өргөтгөхөөр ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 06 тоот албан даалгаврын хүрээнд Мандал суманд 8 аж ахуй нэгж байгууллагын 13 шатахуун түгээх станц ажилладаг бөгөөд дээрх аж ахуй нэгж байгууллагуудад Эко жорлон барьж ашиглалтад оруулах талаар хугацаатай албан бичиг хүргүүлэн ажилласан. Үүний үр дүнд өвлийн улиралд ажилладаггүй байсан 1, шинээр 4 Эко жорлонг барьж ашиглалтад оруулсан.

Сумын Засаг даргын 2022 оны А/363 дугаар “Хуш модны самар бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хүрээнд Барчулуут, Түнхэл чиглэлд хяналтын цэгт хяналтын пост ажиллуулж, хуш модны самар бэлтгэн тээвэрлэх автомашинтай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт 19 аж ахуй нэгж байгууллагын 117 ширхэг зил-131 маркийн автомашинтай гэрээ байгуулаад байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/191 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/379 дугаар захирамжийн хүрээнд 9 багийн 1261 өрхийн 37931 үхэр, 81 өрхийн 3223 гахай нийт 41154 толгой малыг шүлхийн вакцинд хамрууллаа.

Орхон сум:

Улс тунхагласны 98 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн Үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдаанд уран хурц барилдаанаараа Монгол түмнээ огшоож Монгол Улсын АРСЛАН хэмээх эрхэм цол хүртсэн Алдар спорт хороо, “Таванхан” дэвжээний бөх Баярсайханы Орхонбаярт хүндэтгэл үзүүлж, улс аймгийн алдар цолтой 32 бөхийн болон өсвөр үеийн бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрээс хуш модны самар гарал үүслийн гэрчилгээгүй тээвэрлэсэн Баруунбүрэн сумын харьяат 1 иргэнд 500.000 төгрөг, сумын Засаг даргын 2022 оны “Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай” А/43 тоот захирамжийг зөрчсөн сумын 2 иргэнд тус бүр 100.000 төгрөг, Ойн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гарал үүслийн гэрчилгээгүй мод тээвэрлэсэн 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 50.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тус тус тооцож ажиллалаа.

2022 оны мод бэлтгэлийн хуваарийн дагуу Баруунбүрэн сумаас 45 иргэн 180 м.куб түлшний мод, 25 иргэн 50 м.куб гишүү бэлтгээд байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг дэмжих төсөл, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран хэрэгжүүлж байгаа нутгийн үүлдрийн хонийг Франц улсын махны чиглэлийн “Меринос” үүлдрийн хоньтой хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах арга хэмжээнд хамрагдсан 22 өрхийн энэ оны төл болох 200 толгой эрлийз хурганд үзлэг хийх ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг дэмжих төсөл”-ийн мэргэжилтэн, мал зүйч нартай хамтран зохион байгууллаа. “Орхон” хонины зохиомол хээлтүүлгийн ажлыг “Сэлэнгэ үржлийн цөм” сүргийн аж ахуйтай хамтран зохион байгуулж СҮЦСАА, “Мангиртрейд” ХХК, “Орхон далай” ХК, малчин О.Пүрэвдорж нарын суурийн 672 толгой эм хонь хамруулсан байна.

2022 онд зохиомол хээлтүүлэгт үхрээ хамруулсан 32 өрхөөс тус хээлтүүлэгт 25 үхэр хамруулсан 1 малчин өрхийн үнээнд хээлийн шалгалт явуулахад хээл авалт 60 хувьтай тогтоогдоод байна.

Сумын Засаг даргын 2022 оны “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/98 тоот захирамжийн дагуу 308 өрхийн 15000 үхэр, 13 өрхийн 200 гахайг хамрууллаа.

Орхонтуул сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын 2019 оны 41 дүгээр тогтоол, сумын Засаг даргын 2020 оны Б/07 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтнүүд, төсөвт байгууллагын дарга, эрхлэгчдээс хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх цаг үеийн мэдээллийг сонсох зөвлөмж, үүрэг чиглэл өгөх “Мэдээллийн цаг 2022” арга хэмжээг зохион байгуулж, цаг үеийн үүрэг чиглэлийг өглөө.

Сумын Цагдаагийн хэлтэстэй хамтран сумын хэмжээнд иргэдэд “НАМАЙГ АЛГАС”, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулж 126 иргэнийг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2022 оны А/132 дугаар захирамжийн дагуу мал, амьтныг гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтад 529 өрхийн 29200 толгой үхэр, 600 толгой гахай нийт 29800 толгой мал, амьтан хамрууллаа.

Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Орхонтуул сумын Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг”, “Рашаант тосгоны Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг”, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Рашаант тосгонд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх”, “Хонгор-Овоо 3-р багийн байр засварлах”, Баянцогт 2-р багийн “Орон сууцны дээвэр засвар” /2 байр/ ажлуудын гүйцэтгэл 100 хувьд хүрч хүлээн авч ашиглалтад оруулаад байна

Сайхан сум:

Сумын Онцгой комиссын тогтоолын хэрэгжилтийг хангаж Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмж болох унтлагын аппарат, амьсгалын аппарат, бүрэн автомат Биохимийн шинжилгээний аппаратуудыг нийт 114.260.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар зохих хуулийн дагуу худалдан авалт хийж хүлээлгэн өглөө.

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Засаг даргын Тамгын газрын урд талбай буюу Төв талбайг засварлах 2022 оны төлөвлөгөөт ажлыг “Хишиг өндөр” ХХК гүйцэтгэлээ.

“Монгол бахархлын өдөр”-т зориулж түүх, нийгмийн ухааны багш нар санаачлан Хөтөл Соёлын төвийн уран бүтээлчидтэй хамтран 2-12-р ангийн сурагчдадаа соёлын биет бус өв болон үндэсний дээл хувцасны онцлог хэв маягийг танин мэдүүлсэн загварын үзүүлбэр, үндэстэн ястны дуу хөгжмийг таниулсан тоглолтыг зохион байгууллаа.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, түүх өв соёлоо сурталчлан таниулах “Өв соёл” өдөрлөг амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Сант сум:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын хэмжээнд бүдүүн өвс 6288 тн, ногоон тэжээл 30 тн, үйлдвэрийн тэжээл 35 тн, гар тэжээл 2 тн, давс, хужир, шүү 143 тонныг бэлтгээд байна. Бизнес хадлан хийх 10 иргэн, 1 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулснаас 640тн өвс бэлтгэж борлуулсан байна. Сумын нөөцөд 42 тн өвс нөөцөлсөн.

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд хийгдэж буй малын зохиомол хээлтүүлгийн ажлын хүрээнд сумын 20 өрхийн 200 үнээнд герефорд үүлдрийн бухын үрээр зохиомол хээлтүүлэг хийгдсэн. Энэ ажлын гүйцэтгэлд хяналт тавьж Малын удмын сангаас ажлын хэсэг ирж 20 үнээнд үзлэг хийснээс 11 үнээнд хээлтүүлэг хийлээ.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын талаар сумын төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулж 12 хүн хамрагдлаа.

“Сэлэнгэ таван хайрхан” дундын хоршоо, сумын Хөдөө аж ахуйн тасгийн санаачилгаар гишүүн хоршоодыг сурталчлан танилцуулах, хоршооны тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хоршооны нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Сант суманд зохион байгуулж, өдөрлөгт 6 сум, тосгодын 12 хоршоо оролцож өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ танилцуулж 1,7 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагч, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор сумын Засаг даргын ивээл дор “Авьяаслаг Сантчууд” урлаг, спортын наадмыг зохион байгуулж 180 гаруй иргэд хамрагдлаа.

Сүхбаатар сум:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэд, ажил олгогч байгууллагад сурталчлах, сул чөлөөтэй ажлын байрны захиалга авах, иргэдийг бүртгэн холбон зуучлах зорилго бүхий “Ажилд зуучлах өдөрлөг”-ийг зохион байгуулж, мэдээлэл зөвлөгөөг тус сумын 100 гаруй иргэнд өгч ажиллалаа. Өдөрлөгт “Бороо гоулд” ХХК, “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ, “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК, “Алтан тариа” ХХК, “ХААН” банк, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас нийт 150 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлж, тэдгээрт тохирох ажил хайж буй 47 иргэнийг зуучилсан.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжих нийтийг хамарсан ажилд ажилгүй 30 иргэнийг түр ажлын байраар ханган 8 багийн нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 8 га талбайн 24 тн хог хаягдлыг мөн Сумын Засаг даргын 2022 оны “Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах тухай” А/114 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж нийтийн эзэмшлийн гудамж талбайн хогийг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, 4 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт тус тус буулгалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Нэгдүгээрт хүүхэд” арга хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 47 худалдаа, үйлчилгээний газрын төлөөллийг оролцууллаа.

Түшиг сум:

“Хөдөлмөрийн үр шим” ургацын баярын өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй сумын иргэдийг шагнаж урамшууллаа.

- “Алтан гадас” одонгоор иргэн Б.Мөнхжаргал И.Цэдэвхорол
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Жуух бичиг”-ээр иргэн Б.Чинзориг
- Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр М.Үүлэнзая, Л.Баярхүү, Б.Дүвжир,

Б.Цэрэнчимэг, М.Мөнхбат, С.Сүдэръяа

- Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр Л.Энхболд А.Эрдэнэбат нар тус тус шагнагдлаа.

Сумын хэмжээнд үр тарианы хураалт нийт 5151 га талбайд хураалт хийж, гүйцэтгэл 100 хувьтай байна. Үүнд үр тариа 12,1цн буюу 6263 тн, улаан буудай 3853 га талбайгаас хураалт хийснээс ургамал 1971 га талбайгаас 3055 тн, рапс 4155 га талбайгаас 3091,7 тн тус тус хураан аваад байна.

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Тариалан эрхлэлтийг дэмжих санд 4*8 хэмжээтэй нарлаг хүлэмжийг үнэ төлбөргүй аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас олгосон болно.

Хушаат сум:

Сумын Засаг даргын А/88 тоот захирамжаар батлагдсан “Эерэг сэтгэлгээ, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд лхагва гарагийн “Харилцаа ба мэндчилгээ”, “Харилцааны 5 зарчим” сургалтуудыг зохион байгуулж төр, төсвийн албан хаагчийг хамрууллаа.

Сумын Соёлын төв Соёлын бүтээл сарын аяны хүрээнд “Монгол бичиг мину” сайхан бичлэгийн уралдаан, “Үндэсний хувцас сурталчлах өдөр, Дээлтэй монгол” 7 хоногийн аян, “Хаан Чингис” гар зургийн уралдаан, “Эх-хэл эрдмийн түлхүүр” аян, Монгол бичгийн хурдан уншлагын тэмцээн, “Үсэглэлийн хаад” уралдаан, “Дунгийн эгшиг” яруу найргийн уралдаан, “Намрын уянга” дууны тэмцээн зэрэг 8 арга хэмжээг зохион байгуулж нийт 376 иргэнийг хамрууллаа.

Сумын Цаг уурын станцад Засгийн газрын 4.8 сая төгрөгийн санхүүжилтээр цаг уурын автомат станц байрлуулан өдрийн 3 удаагийн ажиглалтаар харьцуулсан тооллогыг хийж байна.

Мөн 1-р багийн малчдад 2022-2023 оны өвлийн улирлын цаг агаарын мэдээг хүргүүлээд байна.

Сумын хэмжээнд нийт 166 өрх түлшний мод бэлтгэж 5741142 төгрөгийг төрийн санд төвлөрүүлээд байна. Үүнээс 1 аж ахуйн нэгж 50 м3 хэрэглээний мод бэлтгэсэн байна.

Хүдэр сум:

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны “Малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлэх тухай” А/108 тушаал, аймгийн Засаг даргын А/243 захирамжийн дагуу сумын 13 малчин, мал

бүхий иргэдийн 315 үнээнд герефорд, лимузин, ангус, хээлтүүлэгч малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил хийгдсэн.

Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 аж ахуй нэгж, 1 иргэний 6149 га-д улаан буудай тариалснаас 9185 тн улаан буудай хураан авсан. Төмс 68 га тариалснаас 520 тн, хүнсний ногоо 46 га-д тариалж 354 тн ургац хураан аваад байна.

Тайлант сард малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд 86 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд адуу 12, үхэр 88, хонь 6, ямаа 7 толгой үхрийн мах 9013 кг, хонины мах 365 кг, ямааны мах 30 кг, гахайн мах 420 кг тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавилаа.

Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт тархалтаас урьдчилан сэргийлэх тухай” А/191 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 2022 оны “Мал амьтны гоц халдварт өвчний талаар авах арга хэмжээний тухай” тухай 02 тоот тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/388, сумын засаг даргын А/120 дугаар захирамжуудын хүрээнд нийт 390 өрхийн үхэр 12200, гахай 500, бүгд 12700 толгой мал, амьтан хамрагдлаа.

Сумын нутаг дэвсгэр орших “Монгол алт” гэх газарт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хайрхан уулын нөмөр” ХХК-ий үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх тухай зөвлөмж хүргэн ажилласан.

Сумын Засаг даргын 2022 оны “Хяналтын цэг ажиллуулах тухай” А/114 дүгээр захирамжийн дагуу Байгаль хамгаалагч, Эрэн хайх салбар анги, Хилийн цэрэг, ХХУТХГН-ийн байцаагч нар хамтран батлагдсан хуваарийн дагуу хяналтын цэгт үүрэг гүйцэтгэн ажилласан. Тайлант хугацаанд нийт 409 иргэн ахуйн зориулалтаар 20450 кг хуш модны самар түүж бэлтгэсэн байна.

2022 оны намар 4,821,400 төгрөгийн санхүүжилтээр төр төсвийн байгууллагууд, 25 аж ахуйн нэгж 140 өрх уг арга хэмжээнд хамрагдаж 3110 ширхэг мод, бутыг тарьж ургуулсан байна. 2022 оны байдлаар төр төсвийн байгууллагын хашаанд 622 ширхэг, нийтийн эзэмшлийн талбайд 240 ширхэг, нийт 862 мод бут ургаж байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ойн дагалт баялгийг хамгаалах ашиглах эрх бүхий 24 аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч 3 аж ахуйн нэгж нийт 1,590,000 тонн самар түүж бэлтгэхээр гэрээ байгуулан ажиллаж, 11 дүгээр сарын байдлаар 18 аж ахуйн нэгж 828,200 кг самар бэлтгэж 52 хувийн гүйцэтгэлтэй, 14 аж ахуйн нэгж 551,015 кг самар гадагш тээвэрлэж 66,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ахуйн зориулалтаар Хан хэнтий улсын тусгай хамгаалалттай газар нутгаас 409 иргэн 20,450 кг самар түүж бэлтгэж 4,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цагааннуур сум:

Сумын Засаг даргын А/118 тоот захирамжийн дагуу “Цагааннуур ургац-2022” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, оёдол, гар урлал, хүнсний ногоо, даршилсан ногоо, мод модон эдлэл зэрэг 7 төрлөөр 21 өрхийн үйлдвэрлэгч, 1 аж ахуй нэгж нийт 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын явуулын үйлчилгээг суманд ажиллаж зорилтот иргэдэд сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны

зөвлөгөө, сумын удирдлагуудад хүүхдийн эрх хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цаашдын ажил арга хэмжээг төлөвлөх чиглэлд санал өгч, газар дээр нь зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Хуурайшилтын үед 51 өрхийн 105 иргэнд ой хээрийн түймэр гарахаас сэргийлэх санамж тарааж, гарын үсгийн баталгаа авсан.

“Бүтээлийн нуур” ХХК-тай хамтран сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн хог түрж, хог асгах талбай бэлдсэн.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг ирж “Алтанбилиг” ХХК-ий уурын зуухны үйл ажиллагаатай танилцсантай холбогдуулан сумын Онцгой комиссын шуурхай хуралдааныг зохион байгуулж хурлаар “Алтанбилиг” ХХК-ий уурын зуухнаас дулаан хангуулдаг хэрэглэгч нарын хүсэлт гомдлын дагуу гэрээ цуцлуулах тухай, мөн мэргэжлийн байгууллага “ЭЛ СИ БИ” ХХК-аар дулаанаа хангуулан ажиллах тухай шийдвэрийг аймгийн Засаг дарга болон, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга нарт хүргүүлээд байна.

Сумын хэмжээнд зохион байгуулсан “Ургацын баяр-2022” арга хэмжээний хүрээнд “Өрхийн хөгжлийг дэмжинэ” хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ Орон нутгийн хөтөлбөр, “БЭСТ” хөтөлбөрийн мэргэжилтнүүд болон сумын удирдлагууд, ногоочид оролцож санал бодлоо солилцож аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 2 иргэн сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр 10 иргэн, сумын шилдгийн шилдгүүдээ тодрууллаа.

Сумын Засаг даргын 2022 оны А/182 дугаар тоот захирамжаар “Золбин нохой устгах” ажлыг зохион байгуулж 1252500 (нэг сая хоёр зуун тавин хоёр мянга таван зуун) төгрөгийг зарцуулж нийт 36 нохой устгаж сумын төвлөрсөн хогийн цэгт булшилж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд ХХААХҮЯ-аас 20*6 харьцаатай хүлэмжийг 8 ногоочинд шинээр олгож гэрээ байгуулан ажиллаж байна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА